



ТЭТГЭВРИЙН УУГАН САН

2023 ЖИЛИЙН ТАЙЛАН





АГУУЛГА

- Гүйцэтгэх захирлын мэндчилгээ 2
- Бүтэц, зохион байгуулалт 3-4
- Гишүүнчлэл 5
- Гишүүдэд чиглэсэн ажлууд 6
- Сангийн хуримтлал 7
- Хөрөнгө оруулалт, өгөөж 8
- Нөөц сан бүрдүүлэлт, орлого зардал 9
- Хараат бус аудиторын тайлан 10-14
- Хяналтын зөвлөлийн баталгаа 15

ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУД



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм гишүүд та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе!

Тэтгэврийн ууган сан /ТУС, сан/ 2023 оны эцсийн байдлаар 1499 гишүүнтэй, 7.5 тэрбум төгрөгийн хуримтлалтай байна. Шинээр хоёр байгууллага нэгдэж гишүүн байгууллагын тоо 11 боллоо.

Бид 2023 онд 6.7 тэрбум төгрөгийн хөрөнгө удирдан ажилласан бөгөөд гишүүдийн багц сонголтын дагуу Зэрэглэл I-ийн хөрөнгө оруулалтад 68.0 хувийг, Зэрэглэл II-ын хөрөнгө оруулалтад 32.0 хувийг байршуулж ажиллаа. Бид

2023 оны гишүүдэд хуваарилах хөрөнгө оруулалтын дундаж өгөөж 11.72 хувь бөгөөд Багц 1 –ийг сонгосон гишүүдэд 12.72%, Багц 2 –ыг сонгосон гишүүдэд 11.93%, Багц 3 –ыг сонгосон гишүүдэд 11.13% өгөөж тус тус хуваариллаа.

Өнгөрсөн жилүүдэд Тэтгэврийн Ууган Сан нь ажилтан, ажил олгогчид харилцан үр ашигтай, хүртээмжтэй, тогтвортой хувийн тэтгэврийн эрх зүйн орчныг бүрдүүлэхийн төлөө хувь нэмрээ оруулж, “Хувийн нэмэлт тэтгэврийн тухай” хуулийн төсөлд санал өгч ирсэн билээ. Уг хуулийн төсөл нь УИХ-ын байнгын хороодоор хэлэлцэгдэж байгаа бөгөөд бидний зорьсон ажил удахгүй үр дүнд хүрнэ гэдэгт итгэж байна.

Тэтгэврийн Ууган Санг үүсгэн байгуулж, тууштай дэмжиж ирсэн Бодь Интернэшнл ХХК, Голомт банк ХК болон ажилтнуудынхаа ирээдүйд хөрөнгө оруулагч Мөнгөн гүүр эмнэлэг, Цэцэнс Майнинг энд энержи ХХК, Голомт капитал ҮЦК, Ашид голомт ББСБ, Бодь пропертийз ХХК, Плас саплай инженеринг ХХК, бусад гишүүн байгууллагын удирдлага, бидэнтэй нэгдсэн гишүүд та бүхэндээ ТАЛАРХАЛ илэрхийлж, амжилт, бүтээлийн дээдийг хүсэн ерөөе!

Хүндэтгэсэн,
гүйцэтгэх захирал



Н.Мөнхжаргал

БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Удирдлага, хяналт

ТУС нь үүсгэн байгуулагчид, гишүүд болон сангийн эрх ашгийн тэнцвэрийг хангахуйц удирдлага, хяналтын тогтолцооны бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулдаг. Үүсгэн байгуулагчид Удирдах зөвлөл болон Хяналтын зөвлөлд төлөөллөө томилж харин гишүүд төлөөллөө санал хураалтаар сонгох замаар сангийн удирдлага, үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлдэг.

2023 оны Бүх гишүүдийн хурлаар 2022 оны тайланг танилцуулж, хөрөнгө оруулалтын багц өөрчлөх эрхтэй гишүүд багцаа өөрчилж, бүх гишүүдийг төлөөлөн Хяналтын зөвлөлд ажиллах хоёр гишүүнийг сонгосон. Сангийн идэвхтэй гишүүдийн 662 гишүүн буюу 52 хувь нь санал өгснөөр санал хураалт амжилттай болж, 2023 онд Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл дараах бүрэлдэхүүнтэй ажиллаа.

Удирдах зөвлөл

Удирдах зөвлөл нь сангийн эрх барих дээд байгууллага бөгөөд сангийн дүрэм, бодлого, журам, бизнес төлөвлөгөө, жилийн тайланг хэлэлцэн батлах, гүйцэтгэх захирлыг сонгон шалгаруулж, томилох эрх үүрэгтэй.



Дарга Г.Ганболд
Үүсгэн байгуулагчаас
томилогдсон Голомт
банкны ерөнхийлөгч



Гишүүн Г.Эрдэнэчимэг
Үүсгэн байгуулагчаас
томилогдсон
Бодь интернэшнл ХХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан захирал



Гишүүн Н.Долгормаа
Бүх гишүүдийн төлөөлөл
Голомт банкны Бүртгэл тооцооны газар, Салбарын мониторингийн хэлтсийн захирал



Гишүүн, ТУС-ийн гүйцэтгэх захирал Н.Мөнхжаргал
Үүсгэн байгуулагчаас
томилогдсон Голомт банкны Комплаенсийн хэлтсийн захирал



Гишүүн А.Ганчимэг
Бүх гишүүдийн төлөөлөл
Голомт банкны Байгууллага хөгжлийн газрын захирал

Хяналтын зөвлөл

Хяналтын зөвлөл нь сангийн санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд хяналт тавьж ажилладаг.



Дарга Л.Өгөөмөр
Бүх гишүүдийн төлөөлөл
Голомт банкны Эрсдэлийн удирдлагын газар, Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хэлтсийн захирал



Гишүүн Б.Туяачимэг
Үүсгэн байгуулагчаас
Голомт банкны Нөөцийн удирдлагын газар, Кастодиан банкны хэлтсийн захирал



Гишүүн Б.Чимэгсүрэн
Бүх гишүүдийн төлөөлөл
Бодь интернэшнл ХХК-ийн Санхүү бүртгэлийн хэлтсийн захирал

Хөрөнгө оруулалт, үйл ажиллагаа

Сангийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг Хөрөнгө оруулалт, Эрсдэлийн удирдлагын бодлогын дагуу удирдан ажилладаг бөгөөд Хөрөнгө оруулалтын хороо нь банкны комплаенс, хөрөнгийн удирдлага, зээлийн үйл ажиллагааны чиглэлд мэргэшсэн туршлагатай гишүүдээс бүрдэн ажиллаж байна.

Хөрөнгө оруулалтын хороо

Хөрөнгө оруулалтын хороо нь Удирдах зөвлөлөөс зөвшөөрсөн эрх хэмжээнд хөрөнгө оруулалтыг удирдах, хянах үүрэгтэй.



Дарга Н.Мөнхжаргал

Тэтгэврийн Ууган Сангийн Гүйцэтгэх захирал,
Голомт банкны
Комплаенсийн хэлтсийн
захирал



Гишүүн Б.Содболор

Голомт банкны Нөөцийн
удирдлагын газрын захирал



Гишүүн Д.Нямдаваа

Голомт банкны Зээлийн
газар, Том зээлийн
хэлтсийн захирал

Гүйцэтгэх баг



Ө.Эрдэнэчимэг

Бизнес хөгжлийн менежер



Л.Баярмаа

Санхүү, үйл ажиллагаа
хариуцсан менежер


Гүйцэтгэх баг

Сангийн өдөр тутмын гишүүн элсүүлэх, байгууллага татах, гишүүд болон гишүүн байгууллагыг холбогдох мэдээллээр хангах, Сангийн маркетинг, идэвхижүүлэлт, гишүүдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг харгалзан үйлчилгээний сэтгэл ханамжийг дээшлүүлэх, Монгол улс болон ТУС сангийн холбогдох дүрэм журам, заавар, НБББ-ийн баримт бичгийн хүрээнд сангийн дотоод үйл ажиллагааг хэрэгжүүлэх, санхүүгийн бүртгэл тооцоог хийх, тайлагнах зөв тодорхой байдлыг хангаж ажилладаг.

ГИШҮҮНЧЛЭЛ

Тэтгэврийн Ууган Сан үүсгэн байгуулагдсан цагаас 2023 оны эцэс хүртэл хугацаанд нийт 4419 гишүүн элсэж, 2920 гишүүн сангийн гишүүнчлэлээс гарсан байна. Үүнээс 2023 онд 475 гишүүн шинээр элсэж, 320 гишүүн сангаас гарч гишүүдийн тоо 1499 боллоо. Шинээр Цэцэнс майнинг энд энержи ХХК, Плас саплай ХХК нэгдэж гишүүн байгууллагын тоо 11 боллоо.

Гишүүдийн хөдөлгөөн



2023 оны жилийн эцсээр нийт гишүүдийн 80 хувь нь 0 - 5 жил хуримтлуулсан, 19 хувь нь 5-с дээш жил хуримтлуулж буй гишүүд байна. Нийт 101 гишүүн санд 10 жилээс дээш хугацаагаар хуримтлуулж, нэрийн дансан дахь хуримтлалаа 100 хувь авах эрхтэй байна.

Сангийн гишүүдийн хуримтлалын хэмжээ, гишүүнчлэлийн жилээр

Гишүүний жил	Гишүүний тоо	Хуримтлал / сая төгрөгөөр	
		1 гишүүний дундаж	Нийт
0-5 жил	1211	1.96	2,368.07
6-10 жил	187	9.13	1,706.90
10-с дээш жил	101	34.55	3,490.14
Нийт дүн	1499	5.05	7,565.11

Сангаас 2023 онд 320 гишүүн 1,433.9 сая төгрөгийн хуримтлал авсан байна. Нийт гарсан гишүүдийн 59 хувь буюу 180 гишүүн өөрийн хүсэлтээр сангаас гарч, 40 хувь буюу 121 гишүүн ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ цуцалж гарсан байна. Тэтгэврийн насанд хүрсэн 4 гишүүн тэтгэвэрт гарч хуримтлалаа 100 хувь авлаа.

ГИШҮҮДЭД ЧИГЛЭСЭН АЖИЛ

- Голомт банк, Бодь группийн ажилтнуудаа тэтгэврийн насанд хүрэх үед хувийн тэтгэврийн нэмэлт орлоготой болгох зорилгоор 2010 онд үүсгэн байгуулагдаж байлаа. Тухайн үед элсэж байсан гишүүдээс 2023 онд гавьяаны амралтаа авсан 6 ахмад гишүүн ТУС сангаас “ХУВИЙН ТЭТГЭВЭР”-ээ авлаа. Тэд зорьсон зорилгодоо үнэнч байж, тууштай хуримтлуулан нийт 120.9 сая төгрөгийн хувийн тэтгэвэр авчээ.



- Бүх гишүүдийн хурал, Хяналтын зөвлөлийн сонгуульд идэвхтэй оролцож амжилттай санал өгсөн гишүүдийнхээ дунд сугалаа зохион байгуулж 9 азтан тодруулж, урамшууллаа.
- Гишүүн байгууллагуудын хүний нөөцийн арга хэмжээнд оролцож ажилтнуудад ТУС сангийн талаар мэдээлэл өгч ажиллаа. Хамгийн олон гишүүнтэй Голомт банкнаас жил бүр зохион байгуулдаг Хөгжлийн Голомт явган аяллын багийг ивээн тэтгэж ажиллаа.
- Мөн уламжлал ёсоор “ТУС-ч Найз” урамшуулалт аян зарлаж идэвхтэй оролцож Байгууллагын тэтгэврийн хөтөлбөрийн давуу талыг сурталчлан 5 найзаа элсүүлсэн гишүүддээ талархал илэрхийллээ.




Бидэнтэй хамтран ажиллаж, зохион байгуулж буй ажлуудад идэвхтэй оролцдог нийт гишүүддээ талархал илэрхийлж, амжилт хүсье.

ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

2023 онд бид хувийн тэтгэврийн сангийн буюу ТУС сангийн үндсэн бүртгэлийн системийг Дижитал кредит компанитай хамтран хөгжүүлж дууслаа. Уг систем нь сангийн гишүүдийн хувийн хэрэг, данс бүртгэл, хуримтлал бүртгэл, гишүүний хуримтлал авах тооцоо, хураамжийн тооцоо, хөрөнгө оруулалтын бүртгэл, өгөөж тооцоолол, өгөөж хуваарилалт зэргийг нэгдсэн байдлаар бүртгэх, цаашид бусад системтэй холбох, хөгжүүлэх боломжийг бүрдүүлж байна.

Шинэ систем нэвтрүүлсэнтэй холбоотой ТУС сангийн гишүүдийн бүртгэл, хуримтлалын 14 жилийн түүхэн датаг хөрвүүлэх, хуучин болон шинэ системд зэрэгцүүлэн хөтөлж, тестлэх, нягтлах ажлууд хийлээ.



2023 онд Сангийн Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн хамтарсан хурлын 9 удаа хийж, санхүүгийн тайлан, бизнес төлөвлөгөө, гүйцэтгэлийг хэлэлцэн, Эрсдэл тогтворжилтын журмыг хүчингүй болгож Нөөц сангийн журмыг баталсан. Мөн журмын өөрчлөлттэй холбоотойгоор дүрэмд өөрчлөлт орууллаа.

Сангийн удирдлага, ажилтнуудыг мэргэшүүлэх зорилгоор нийт баг хамт олныг Эй Ай Эс ХХК-ийн Хувийн тэтгэврийн сангийн хөрөнгө оруулалтын удирдлага сэдэвт сургалт, Удирдах зөвлөлийн гишүүнийг Хөрөнгө оруулалтын зуучлалын үйлчилгээ эрхлэх эрх олгох сургалт, Санхүү, үйл ажиллагаа хариуцсан менежерийг Татварын мэргэшсэн зөвлөх бэлтгэх сургалтад тус тус хамрууллаа.

Сангийн 1694 гишүүний хуримтлалыг бүртгэж, 320 гишүүний гаралтын тооцоо хийж, 97 гишүүнд тодорхойлолт гаргаж, гишүүн байгууллагуудтай улирал тутам тооцоо нийлж, сангийн санхүү, татварын тайлан тооцоог хуулийн дагуу хийж, жилийн тайланд Гроут Финанс Аудит ХХК-р хөндлөнгийн аудит хийлгэж, Хяналтын зөвлөлөөр хянуулан баталгаажуулж ажиллаа.

САНГИЙН ХУРИМТЛАЛ

2023 оны эцсийн байдлаар сангийн 1499 гишүүн нийт 7.6 тэрбум төгрөгийн хуримтлалтай байна. Энэ хуримтлалын 3.2 тэрбум нь хөрөнгө оруулалтын үр дүнд хуримтлагдсан өгөөж, 2.2 тэрбум нь гишүүдийн цалингаасаа, 2.2 тэрбум нь ажил олгогчдоос ажилтнуудынхаа нэрийн дансанд шилжүүлсэн хуримтлал байна.



2023 онд гишүүн болон гишүүн байгууллагаас нийт 1.5 тэрбум төгрөг гишүүдийн нэрийн дансанд нэмэгдэж, ТУС-аас 0.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын өгөөж хуваарилсан. Харин Сангаас 320 гишүүн гарсантай холбоотой нийт 1.8 тэрбум төгрөгийн хуримтлал гарсан.

Гишүүдийн хуримтлалын хөдөлгөөн

Гишүүдийн хуримтлалын хөдөлгөөн	Сая төгрөгөөр
1 Гишүүдийн хуримтлал эхний үлдэгдэл	7,051.8
2 Гишүүдийн нэмэгдсэн хуримтлал	1,543.2
3 Гарсан гишүүдийн хуримтлал	(1,815.5)
4 2023 онд хуваарилсан өгөөж	785.6
ГИШҮҮДИЙН НИЙТ ХУРИМТЛАЛ	7,565.1

2023 онд сангаас гарсан гишүүдэд 1.4 тэрбум төгрөгийн хуримтлал тооцож олгосон бөгөөд ХХОАТ-ын тухай хуулийн дагуу 102.1 сая төгрөгийг татварын байгууллагад, гэрээний дагуу 183.7 сая төгрөгийг ажил олгогчид, 93 сая төгрөгийг нөөц санд шилжүүллээ.



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ӨГӨӨЖ

2023 онд нийт гишүүдийн 37 хувь Багц 1-ийг, 29 хувь Багц 2-ыг, 34 хувь Багц 3-ыг сонгосон байна. Хуримтлалын хэмжээгээр багц 3-ыг сонгосон гишүүдийн хуримтлал нийт хуримтлалын 47 хувь байна.


Дээрх сонголтын дагуу 6.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын 68 хувийг банкны хадгаламжид, 10 хувийг дотоод, гадаадын хувьцаанд, 22 хувийг компанийн бондод байршуулж ажиллаа.

Хувьцааны багцад Түмэн шувуут, АПУ, Голомт банк, Мандал даатгал, Инвескор ББСБ, Сэнтрал Экспресс Си Ви Эс, China Construction Bank, Industrial and Commercial Bank of China зэрэг хувьцаанууд байна.


Хадгаламжийн хүү өнгөрсөн онтой харьцуулахад өсөлттэй байсан бол хөрөнгийн зах зээлд хувьцааны ханш уналттай байсантай холбоотой сангийн хөрөнгө оруулсан хувьцааны багцаас 9.6 хувийн алдагдал хүлээлээ. Харин бондын хөрөнгө оруулалтаас оны дунджаар 16.2 хувийн өгөөжтэй байлаа.

Сангийн хөрөнгө оруулалт, эрсдэлийн удирдлагын бодлогын дагуу 2023 оны хөрөнгө оруулалтын дундаж өгөөж 11.7 хувь бөгөөд Багц 1 12.7 хувь, Багц 2 11.9 хувь, Багц 3 11.1 хувийн өгөөж тус тус хуваариллаа.


Гишүүдийн багц сонголт хуримтлалаар



Хөрөнгө оруулалт төрлөөр



Гишүүдийн багц сонголт хуримтлалаар



НӨӨЦ САН БҮРДҮҮЛЭЛТ, ОРЛОГО ЗАРДАЛ


ТУС нь гишүүдийнхээ хуримтлалын үнэ цэнийг хадгалах, найдвартай өсгөх зорилгоор нөөц сан бүрдүүлж ажилладаг. Нөөц сангаас зөвхөн Удирдах зөвлөлөөр батлагдсан бизнес төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг санхүүжүүлэх ба шаардлагатай тохиолдолд Удирдах зөвлөлийн хурлын шийдвэрээр гишүүдэд хуваарилах өгөөжийн доод түвшинг хангах зардлыг гаргадаг. 2023 онд Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн хамтарсан хурлын шийдвэрээр нөөц сангаас 76.2 сая төгрөг зарцуулж, гишүүдэд хуваарилах өгөөжийг нэмэгдүүллээ.

Нөөц сангийн хөдөлгөөн (сая төгрөгөөр)

Эхний үлдэгдэл	1,211.8
Гарсан гишүүдээс санд үлдсэн	88.6
2023 оны өгөөж нэмэгдүүлсэн	-76.2
Эцсийн үлдэгдэл	1,224.1

ТУС нь 2023 онд 33.6 сая төгрөгийн гишүүний татвар, 156.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын хүүгийн орлого, нийт 189.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, үйл ажиллагаанд 169.4 сая төгрөг зарцуулж, 20.5 сая төгрөгийн үр дүнтэй ажиллаа. 2023 оны үйл ажиллагааны зардлын төсвийн гүйцэтгэл 70 хувьтай байна.

Сангийн орлого, зарлага (сая төгрөгөөр)



Үйл ажиллагааны төсөв, гүйцэтгэл, 2023 он

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
I. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ	130.6	76.6	58%
Удирдлагын үйл ажиллагааны зардал	36.3	50.4	138%
Програм, Вэб хөгжүүлэлт	68.6	0.5	0%
Зар сурталчилгаа, сургалт	25.7	25.7	100%
II. ЦАЛИН ХӨЛСНИЙ ТӨСӨВ	108.6	92.8	85%
НИЙТ ТӨСӨВ	239.2	169.4	70%



ТЭТГЭВРИЙН УУГАН САН

ХӨНДЛӨНГИЙН АУДИТЫН ДҮГНЭЛТ



ГРОУТ ФИНАНС АУДИТ ХХК

ГРОУТ ФИНАНС АУДИТ ХХК

Аудит, нягтлан бодох бүртгэл, бизнесийн зөвлөгөө

Монгол Улс, Улаанбаатар хот 14200, Баянгол дүүрэг,
2 дугаар хороо, Эрхи Цогцолбор төв 603 тоот
И-мэйл: info@growthfinance.mn, Утас: 976-9909 4391

Огноо 2024.02.07 Дугаар 02/03

“Тэтгэврийн Ууган Сан” ТББ-ийн
Хувьцаа эзэмшигчид

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Санхүүгийн Тайлангийн Аудитын Талаарх Тайлан

Дүгнэлт

Тэтгэврийн Ууган Сан Төрийн бус байгууллага /цаашид ТУС ТББ гэх /- ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол бүхий нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, Тэтгэврийн Ууган Сан ТББ-ын санхүүгийн тайлан нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (цаашид АОУС гэх)-ын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартын дагуу хүлээсэн үүрэг хариуцлага энэхүү тайлангийнхаа *Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх Аудиторын үүрэг хариуцлага* хэсэгт харуулсан. Эдгээр стандарт нь санхүүгийн тайланг материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, мөн мэргэжлийн ёс зүйн шаардлагуудыг даган мөрдөхийг биднээс шаарддаг. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай, зохих үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.



Гроут Финанс Аудит ХХК
Монгол улс, Баянгол дүүрэг, 2-р хороо
Баруун 4 зам Улаанбаатар 14200
603 тоот, Эрхи цогцолбор,

2024 оны 02 дугаар сарын 07-ны өдөр



ТЭТГЭВРИЙН УУГАН САН ТББ
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

<i>(Төгрөгөөр)</i>	<i>Тодруулга</i>	2023.12.31	2022.12.31
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4	88,386,999.81	118,478,594.05
Богино хугацааг хөрөнгө оруулалт	5	7,404,639,493.25	6,850,000,000.00
Дансны авлага	6	498,879,904.63	328,596,849.32
Бараа материал	7	390,000.00	390,000.00
Урьдчилж төлсөн зардал / тооцоо	8	59,411,250.00	59,411,250.00
Эргэлтийн хөрөнгийн дүн		8,051,707,647.69	7,356,876,693.37
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	9	-	175,960.98
Биет бус хөрөнгө	10	765,000.00	945,000.00
Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө	11	833,409,703.38	962,367,465.69
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		834,174,703.38	963,488,426.67
ХӨРӨНГИЙН ДҮН		8,885,882,351.07	8,320,365,120.04
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
Өр төлбөр			
Дансны өглөг	12	27,244.35	58,361.63
Цалингийн өглөг	13	15,909,167.98	13,205,146.64
Татварын өглөг	14	49,454,017.76	32,698,726.01
Богино хугацааг өр төлбөрийн дүн		65,390,430.09	45,962,234.28
Урт хугацааг өр төлбөр			
Бусад урт хугацааг өр төлбөр	15	7,565,107,637.40	7,051,829,101.56
Нийт өр төлбөрийн дүн		7,630,498,067.49	7,097,791,335.84
Эздийн өмч			
Хязгааргүй нөөц		1,224,105,174.37	1,211,783,454.88
Хуримтлагдсан ашиг (алдагдал)		31,279,109.21	10,790,329.32
Эздийн өмчийн дүн		1,255,384,283.58	1,222,573,784.20
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		8,885,882,351.07	8,320,365,120.04

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн саллигүй хэсэг болно.



ТЭТГЭВРИЙН УУГАН САН

ТЭТГЭВРИЙН УУГАН САН ТББ
ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

<i>(Төгрөгөөр)</i>	<i>Тодруулга</i>	2023.12.31	2022.12.31
Гишүүдийн татвар	16	33,543,200.06	34,260,250.01
Хөрөнгө оруулалтын орлого	17	156,376,459.74	108,356,701.69
Үндсэн үйл ажиллагааны орлого		189,919,659.80	142,616,951.70
Үндсэн үйл ажиллагааны зардал	18	169,430,879.91	141,216,747.62
Үндсэн үйл ажиллагааны үр дүн		20,488,779.89	1,400,204.08
Бусад дэлгэрэнгүй орлого			
Орлогын албан татварын зардал		-	342,876.49
Тайлант оны цэвэр үр дүн		20,488,779.89	1,057,327.59

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн саллигүй хэсэг болно.



ТЭТГЭВРИЙН УУГАН САН ТББ
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

(Төгрөгөөр)

	Хязгаарлалтгүй нөөц	Хязгаарла лттай нөөц	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
2022 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	1,275,892,159.64		9,733,001.72	1,285,625,161.36
Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)			1,057,327.59	1,057,327.59
Өмчид гарсан өөрчлөлт	(64,108,704.76)			(64,108,704.76)
2023 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	1,211,783,454.89		10,790,329.31	1,222,573,784.20
Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)			20,488,779.89	20,488,779.89
Өмчид гарсан өөрчлөлт	12,321,719.49			12,321,719.49
2024 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	1,224,105,174.38		31,279,109.20	1,255,384,283.58

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн саллигүй хэсэг болно.

ТЭТГЭВРИЙН УУГАН САН ТББ
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

(Төгрөгөөр)	2023.12.31	2022.12.31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого:	6,560,981,710.98	6,340,295,734.92
Гишүүдийн татвараас орсон мөнгө	28,999,200.06	34,258,250.01
Бусад	6,531,982,510.92	6,306,037,484.91
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага:	6,673,150,867.62	5,120,984,229.51
Ажилчдад олгосон мөнгө	87,036,067.23	79,667,854.39
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	12,332,738.73	9,814,243.68
Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	4,737,704.00	2,340,000.00
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	110,870.00	30,000.00
Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн бусад мөнгө	183,675,483.99	221,147,150.57
Төлсөн татвар	102,196,153.32	74,800,931.69
Бусад зардалд төлсөн мөнгө	6,283,061,850.35	4,733,184,049.18
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(112,169,156.64)	1,219,311,505.41
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Худалдсан хөрөнгө оруулалтын орлого	1,330,000,000.00	431,785,656.01
Худалдаж авсан хөрөнгө оруулалт	(1,350,000,000.00)	(1,625,246,090.00)
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	(20,000,000.00)	(1,193,460,433.99)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Банкны зээл /Гишүүдийн хуримтлал/ Урт хугацаат өрийн тайлангийн хугацааны төлөлт	1,557,686,674.99	1,098,239,492.51
	(1,455,609,112.59)	(1,159,816,039.67)
Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээ	102,077,562.40	(61,576,547.16)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(30,091,594.24)	(35,725,475.74)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	118,478,594.04	154,204,069.78
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	88,386,999.80	118,478,594.04

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн саллигүй хэсэг болно.

ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН БАТАЛГАА



“ТЭТГЭВРИЙН УУГАН САН” ТББ-ЫН ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ШИЙДВЭР

2024 оны 02 сарын 13-ны өдөр

Дугаар ХЗ-24/01

Улаанбаатар хот

2023 оны санхүүгийн тайлан, гишүүдэд хуваарилах өгөөжийн тооцооллыг хянасан тухай

Тэтгэврийн ууган сан ТББ-ын дүрмийн 5.10-т заасны дагуу Хяналтын зөвлөл нь 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдөр хуралдаж дараах асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргав:

- i. Тэтгэврийн Ууган Сан ТББ-ын 2023 оны санхүүгийн тайлан болон аудитын дүгнэлтийг хянан баталгаажуулах тухай;
- ii. Гишүүдэд хуваарилах 2023 оны хөрөнгө оруулалтын өгөөжийн тооцооллыг хянан баталгаажуулах тухай;

Шийдвэрлэсэн нь:

1. Тэтгэврийн Ууган Сан ТББ-ын санхүүгийн байдлын тайлан болон Гроут финанс ХХК-ийн аудитын дүгнэлтийг хянан баталгаажуулж байна.
2. Гишүүдэд хуваарилах 2023 оны хөрөнгө оруулалтын өгөөжийн тооцооллын дараах үр дүнг хянан баталгаажууллаа. Үүнд:
 - 2.1. Удирдах зөвлөлийн 2024 оны 01 сарын 11-ний өдрийн УЗ-24/02 тогтоолын дагуу гишүүдэд хуваарилах дундаж өгөөжийг 11.70 хувьд хүргэж нөөц сангаас 76,226,768.01 төгрөгөөр дүүргэлт хийснийг;
 - 2.2. Багц I-д 12.72 хувь, Багц II-т 11.93 хувь, Багц III-т 11.13 хувийн өгөөж тус тус ноогдохоор тооцсоныг баталгаажуулав.
3. Цаашид хувьцааны багцийн өгөөжийг сайжруулж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Н.Мөнхжаргал/-д зөвлөж байна.
4. Энэхүү шийдвэрийн хувийг Удирдах зөвлөл (Г.Ганболд)-д хүргүүлсүгэй.

ДАРГА:

ГИШҮҮД:



Л.ӨГӨӨМӨР

Б.ТУЯАЧИМЭГ

Б.ЧИМЭГСҮРЭН

ТЭТГЭВРИЙН УУГАН САН

Δ.Сүхбаатарын талбай 5, Ш/Х-22
Улаанбаатар 15160, Монгол улс
7011 1645 - /1284, 1679/
info@tus.mn
www.tus.mn

